

МОНГОЛ УЛСЫН МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН
УРВУУЛАН ХЭРЭГЛЭЭ, ХОР УРШИГ, ШИЙДВЭРЛЭХ

АРГА ЗАМУУД

Б. Эрдэнэдалай, Ц. Баясгалан, Г. Хатанбаатар

Дотоод Хэргийн Их Сургуулийн Удирдлагын

Академи, Онцгой байдлын сургууль

Цахим хаяг: bshumaa@yahoo.com

Хураангуй

Монгол Улсын сүүлийн 30 жилийн нийгэм, эдийн засаг, улс төрийн олон олон өөрчлөлтийн хүрээнд бий болсон нэгэн сөрөг үзэгдэл бол бидний хар тамхи гэж нэрлэж, жигшдэг мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хууль бус хэрэглээний асуудал бөгөөд сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн тоо, хууль бус нийлүүлэлт өсөн нэмэгдсэн, тэдгээр бодисын төрөл зүйл олширсон төдийгүй хууль ёсны зах зээл буюу хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйл хэрэгт ашигладаг эм бэлдмэлийг мансуурах зорилгоор урвуулан хэрэглэдэг, гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсэн, ирээдүй хойч үе, хүүхэд залуучууд ихээр холбогдох болсон, Африк (баруун) гаралтай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа манай улсад идэвхжсэн нь нийгэм, эдийн засагт төдийгүй улс, үндэстэний аюулгүй байдалд заналхийсэн асуудал болсон байна. Үүнтэй уялдан үүсэн бий болсон тулгамдсан асуудлын шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны арга хэрэгсэл ашиглан бодитой тодорхойлж, тэмцэх менежментийг оновчтой байдлаар зохион явуулах боломжийг судлах нь уг салбарт 10 жил ажиллаж туршлага хуримтлуулсан мэргэжилтэн, судлаачийн хувьд уг салбарт хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж судалсан.

Судалгааг эхний суурь судалгаа болох мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хууль ёсны эргэлттэй холбоотой нөхцөл байдлыг төрийн байгууллагын тайлан мэдээ тоон судалгаанд анализ, тандан судлах аргаар Монгол Улсын хүн, амьтны эмчилгээ оношилгоонд хэрэглэгдэж буй эмийн зарцуулалт, хэрэглээ, урвуулан хэрэглээ, борлуулалт, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, уг салбарын эдийн засгийн эргэлтийн ерөнхий зураглалыг боловсруулан цаашид бий болох эрсдлийг тодорхойлсноор урьдчилан сэргийлэх боломжтой эсэхийг тогтоох, энэхүү таамаглалын бодитой эсэхийг магадлан тогтоох, хууль эрх зүйн орчинд шийдвэрлэх аргыг тодорхойлох, боловсронгуй болгох талаар манай оронд судлагдсан байдал, цаашид илүү ач холбогдол, анхаарал хандуулан хөндөн судлах шаардлагатай байгаад баримт бичгийн судалгаа хийж энэхүү илтгэлийг бичсэн болно. Энэхүү илтгэл нь дараагийн нэг сэдэвт судалгааны ажлын зөвхөн эхлэл гэдгийг дурьдах нь зүйтэй.

Түлхүүр үг: Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодис, Монгол Улсын хүн, амьтны эмчилгээ оношилгоонд хэрэглэгдэж буй эмийн зарцуулалт, хэрэглээ, урвуулан хэрэглээ, хор уршиг, хууль ёсны эргэлт

Судалгааны ажлын судлагдсан байдал

Монгол Улсын хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хууль бус эргэлттэй холбоотой нөхцөл байдлыг илүү анхааран судалдаг бөгөөд одоогоор хууль ёсны эргэлт, үүнээс үүсэн бий болж буй эрсдэл, хор уршгийг судалсан судалгааны ажил хийгдээгүй, харин хууль ёсны эргэлттэй холбоотой журам зөрчсөн хэрэг, үйлдлийг илрүүлэх, мөрдөн шалгах арга, ажиллагаатай холбоотой зааварчлага гарын авлага бага байна. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” сэдэвт докторын зэрэг горилсон судалгааны ажлаа ОХУ-ын эрдэмтэн Харьковский Сленг 2002 онд бичин, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн үндэслэлийг гаргаж ирсэн (Сленг, 2002).

“Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үйл явцыг удирдах нийгмийн асуудлууд” сэдэвт докторын зэрэг горилсон ажлаа ОХУ-ын эрдэмтэн Ведров С.Ю бичин, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг нотолж, өсвөр насныхны мансууруулах бодис хэрэглэх хандлагыг сэтгэлзүйн оношлогоо, синтезжүүлсэн эмийн хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй өгүүлсэн (С.Ю., Ведров, 2019).

“Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус хууль бус эргэлттэй тэмцэх” сэдэвт докторын зэрэг горилсон ажлаа ОХУ-ын эрдэмтэн В.В. Измайлова судалгааны ажилдаа Бүгд Найрамдах Карель Улсын хар тамхины наймааны жишээг ашигласан байна (Измайлова.В.В, 2019).

“Хар тамхины донтолтыг хянан эмчлэх” сэдэвт докторын зэрэг горилсон судалгааны ажлаараа, эрдэмтэн, Кервин Кайе Брук нь сүүлийн хорин жилийн хугацаанд хар тамхинд донтогчдын тоо өссөнг дурьдаж, эрүүгийн эрх зүйн тогтолцоонд улам бүр анхаарал татаж байна. Эрүүгийн яллагдагчдыг хорихоос илүүтэй эмчилгээний хөтөлбөрт хамруулан, давтан хийх гэмт хэргийн гаралтыг багасгаж, хөтөлбөрт хамрагдагчдын сургалтад зориулан төрөөс олгож буй зардлыг бууруулан төрөөс тавих хяналтыг сайжруулахад хувь нэмрээ оруулсан (Brook, 2010).

“Косово дахь хар тамхины эсрэг үндэсний стратеги, мансууруулах бодистой тэмцэх бодлого, хууль сахиулах ажиллагааны туршлага” сэдэвт докторын зэрэг горилсон судалгааны ажлаараа, эрдэмтэн Ферид Аземи нь Зүүн Өмнөд Европын Бүгд Найрамдах Косово Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд насанд хүрээгүй хүмүүсийн хар тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн стратеги хэрэгжилтийн үр нөлөөг судлахдаа тухайн улсын засгийн газар хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2009 онд мансууруулах бодистой тэмцэх анхны бодлогын хэрэгжилтийг дүгнэсэн (Azemi, 2019).

Гадаад улс орны хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй арга зам, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг уншиж судлахад энэ төрлийн бодисын хууль ёсны эргэлтэд тавих хяналтын оновчтой бус байдал, анхаарал сулруулсан зэргээс үүсэн бий болсон нийгмийн хор уршиг нь илүү, манай улсын эрх бүхий байгууллагаас ач холбогдол өгөхгүй, анхаарал тавих асуудлын эрэмбийн жагсаалтанд оруулахгүй байгаа нь анхаарал татаж, энэхүү сэдвийг судлахаар зорив.

Ийнхүү судлахын тулд судалгааны ажлын сэдвийн агуулгыг илэрхийлэх үндсэн нэр томьёо, эрүүл мэнд, нийгмийн шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил, хэвлэн гаргасан ном, гарын авлага, эрх бүхий байгууллагын тайлан, мэдээтэй танилцаж, аль болох шинэлэг санааг хөндөн гаргаж судлах, олон хүчин зүйлийн

хамаарлын зүй тогтол, онол арга зүйн болон чанарын судалгааг үндэслэлээ болгосон.

Судалгааны зорилго

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хууль ёсны хэрэглээ, урвуулан хэрэглээний өнөөгийн нөхцөл байдлыг бодитой танилцуулахад оршино.

Судалгааны зорилтууд;

- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын тайлан, нөхцөл байдлын мэдээнд дүн шинжилгээ хийх замаар таамаглалыг бататгах
- Сэдвийн хүрээнд нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг, нөлөөллийн талаар эрдэмтэн, судлаач, шинжээчдийн бэлтгэсэн судалгааны ажил, илтгэлийг судлах
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай хууль, холбогдох хууль эрх зүйн орчин судлах, дүгнэлт хийх замаар шийдвэрлэх аргыг тодорхойлох, боловсронгуй болгох талаар нөхцөл байдалд үндэслэсэн дүгнэлт хийх, санал гаргах;

Судалгааны аргачлал

- Контентийн анализ, синтез
- Нэгтгэн дүгнэх
- Бичиг баримтын судалгаа

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хувьд, Мансууруулах бодисын тухай 1961 оны конценцод 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай НҮБ-ын 1971 оны конценцод 1999 онд, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцод 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод 2008 онд тус тус нэгдэн орсон нь энэхүү чиглэлээр олон улсын өмнө үүрэг, хариуцлага хүлээж байгаагийн тод илрэл юм. Ийнхүү НҮБ-ын дээрх конвенцуудад нэгдэн орсноор 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль, 2003 оны 8 дугаар сарын 27-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн Газрын 196 дугаар тогтоолоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хилээр нэвтрүүлэх гаалийн боомт, Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт, эдгээр бодисыг ашиглах байгууллагын жагсаалт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглах, хадгалах, устгах журам, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх” журмыг батлан хэрэгжүүлж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн эргэлттэй холбоотой харилцааг зохицуулж байна (ЦЕГ, 2019). НҮБ-ийн 2016 оны тайланд, дэлхийд 247 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, үүнээс 29 сая хүн нь уг бодисоос шууд хамааралтай болсон талаар дурдсан байна (Х.Доржсүрэн, 2018).

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын эргэлтийн нөхцөл байдал

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн талаарх 2019 оны илтгэлдээ опиоид

/морфин/ төрлийн, мансууруулах бодис нь хүний эрүүл мэндэд хамгийн хор уршигтай

нөлөө үзүүлсэн хэвээр байгаа бөгөөд нийт 11 сая хүн тарилгаар тогтмол хэрэглэдэг, тэдний хагасаас илүү нь гепатит С, 8 хэрэглэгчийн 1 нь ДОХ-той амьдарч байна (НҮБ, 2019).

Хууль бус мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос гадна эмчийн зааврын дагуу хэрэглэгчид хүргэдэг эмийн зүй бус хэрэглээ ноцтой түвшинд хүрч байгаа бөгөөд тухайлбал опиоид төрлийн өвчин намдаагч болон трамадол эмийн хууль бус эргэлт Африкт өргөжиж, цаашлаад Ойрх Дорнодод мөн нэмэгдэх хандлагатай болжээ. Хойд Америкийн хувьд, синтетик опиоид болох фентанилын хэрэглээнээс улбаалсан нас баралтуудын тоо өссөөр байгааг онцлон тэмдэглэсэн байна (Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газар, 2019).

Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг ЭМЯ-аас, аймаг нийслэлд эмийн сан, эмнэлгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас олгодог.

Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн мансууруулах эм 8 нэрийн 11 төрөл, сэтгэцэд нөлөөт эм 11 нэрийн 27 төрөл буюу нийт 19 нэрийн 38 төрлийн эмийг эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэдэг бөгөөд 2020 оны байдлаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодис импортлох, түгээх тусгай зөвшөөрөл бүхий 9 аж ахуйн нэгж мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж 300 эмийн сан, Улаанбаатар хотод мансууруулах үйлчилгээтэй эмээр иргэдэд үйлчлэх эрхтэй 12 нийтийн эмийн сан, 250 гаруй хүн эмнэлэг, 33 мал, амьтны эмнэлэг, аймгийн төвүүдэд хүн амын тооноос хамаарч 1-2 эмийн сан, мал эмнэлэг үйл ажиллагаа явуулж энэ төрлийн эм, тариаг түгээдэг.

2020 онд Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн худалдан борлуулсан эмийн үнэ 2.6 тэрбум /Ханган нийлүүлэх байгууллагууд эмнэлэг, эмийн санд бөөнөөр олгох үнийг дундажлаж тооцсон/ орчим төгрөгийн эргэлт хийгдсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж журам зөрчсөн, албан тушаалаа урвуулан ашигласан үйлдэлд шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 20.9-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, зөрчлийн шинжтэй үйлдлийг мэргэжлийн хяналтын байгууллагад харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэж байна

Тухайлбал 2020 онд Мэргэжлийн хяналтын газартай хамтран Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа зарим сүлжээ эмийн сангийн үйл ажиллагааг шалгахад орлого, зарлага, зарцуулалтын бүртгэлгүй, дутуу, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хуурамч, хүчингүй, энгийн эмийн жороор худалдсан, хадгалах зориулалтын төмөр шүүгээ, хамгаалалтын систем хангалтгүй, эмийн санч нар сэтгэцэд нөлөөт эмийг дутаасан, алба тушаалаа урвуулан ашиглаж завшсан байж болзошгүй гэмт хэргийн шинжтэй 17 үйлдэл илрүүлэн эзэн холбогдогчийг эрүүгийн хариуцлагад татаж, зөрчлийн 76 үйлдэлд хариуцлага тооцуулахаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт шилжүүлсэн байна.

Шинэ төрлийн бодисын талаар

Монгол Улсад хүн амын эмчилгээнд хэрэглэх, шинжилгээ, судалгааны зорилгоор

ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт байгаа боловч хориглосон болон шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт байхгүй байна. Хөрш улсуудын туршлагаас хархад НҮБ-ын конвенцийн жагсаалтаас гадна дотооддоо хянах бодисын жагсаалтыг баталсан байдаг. Тухайлбал БНХАУ нь 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр мансууруулах үйлчилгээтэй 121, сэтгэцэд нөлөөт 68, шинэ төрлийн 81 бодисын жагсаалтыг баталж байсан бол 2017 онд шинэ төрлийн 120 мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг шинэчлэн баталсан байна. Харин ОХУ-ын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн тогтоолоор олон улсын гэрээ, хуулиар хориглосон, эргэлтийг хязгаарлан хяналтад авсан болон хяналт тавих шаардлагатай мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг тус тус шинэчлэн нэмж бүртгэсэн (ЦЕГ, 2019).

Манай улсын өсвөр насны хүүхэд залуучууд “Декстрометорфон” бодис агуулсан “Комикс” нэртэй шингэн эмийг 10-аас 30 ширхэгээр нэг доор ууж мансуурах, “DXM” буюунунтаг цагаан өнгөтэй “Dextromethorphan” бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зарж борлуулах, хэрэглэх явдал цагдаагийн байгууллагад бүртгэгдэх болсон.

Декстрометорфон бодис нь 1949 онд анх патентлагдсан бөгөөд 1933 оноос эмийн бэлдмэлд тооцогдох болсон байна. НҮБ-ын 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенцийн жагсаалтад байсан бодис юм./Конвенцийн заалтаас ... Дээр заасанчлан эфир буюу хүнд эфир болон изомерын давсууд байж болох тохиолдолд тэдгээрийг оролцуулан энэ жагсаалтад орсон мансууруулах эмийн давсууд,* Dextromethorphan ((+)-3- methoxy-N-methylmorphinan) болон dextrorphan ((+)-3-hydroxy-N- methylmorphinan) энэ жагсаалтаас тусгайлан хассан болно (Мансууруулах эмийн тухай, 2005) гэжээ./

Хар тамхитай тэмцэх газраас хүргүүлсэн хүсэлтийн дагуу декстрометорфон бодис болон комикс эмийн талаар Эрүүл мэндийн яамны Хүний эмийн дэргэдэх Эм судлалын Салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн /№5/ хурлаар хэлэлцэж дээрх эм болон бодис нь хүний сэтгэцэд ямар нөлөө үзүүлдэг болон тун хэтрүүлэн хэрэглэхэд хүний эрүүл мэндэд ямар сөрөг нөлөө гардаг тухай 3 чиглэлээр мэдээллийг ирүүлсэн. Үүнд:

1. Эмчилгээний тунгаар хэрэглэхэд илрэх сөрөг нөлөө /15 мг-35 мг/
2. Тун хэтрэлтийн үед гарах сөрөг нөлөө /3-10 дахин их тун/
3. Тун хэтрэлтийн үед гарах сөрөг нөлөө ба цочмог хордлого /15-75 дахин их тун/

Тун хэтрэлтийн үед гарах сөрөг нөлөө ба цочмог хордлогын үед ердийн тунгаар хэрэглэхэд илэрдэг гаж нөлөө болон тун хэтрэлтийн үед илэрдэг гаж нөлөө илрэхийн зэрэгцээ нэмэгдээд дараах гаж нөлөө үзүүлнэ.

- Хөлрөх
- Сэтгэцийн үйл ажиллагаа өөрчлөгдөх
- Хүүхэн хараа өргөсөх
- Юм хоёр болж харагдах
- Нүдэнд цус хурах
- Амьсгалын дутмагшилд орох
- Зүрхний цохилт олшрох
- Мэдрэх мэдрэхгүй өөрчлөгдөх
- Нүдний фокус алдагдаж юм харахаа болих

- Татаж унах
- Шээс хоригдох зэрэг нөлөө илэрдэг бөгөөд зарим ноцтой тохиолдолд амь насанд аюултай байдаг. Ердийн тунгаар байнга давтан хэрэглэвэл сэтгэцийн хамаарал үүсдэг: /Өөрөөр хэлбэл уг эмэнд хамааралтай болж донтох эмгэгшил үүсдэг (Шийдвэр, 2019)/

Монгол Улсын эмийн бүртгэлийн F100810RN02463, F100810RN02464 дугааруудад Индонези Улсын PT.Bintang Toedjoe үйлдвэрийн “Комикс” нэртэй /жинжер, лайм, пепперминт/ буюу найрлагандаа Декстрометорфан 15мг агуулан сироп эмүүдийг 2010 оны 8 дугаар сарын 10-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн ба бүртгэл нь 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс манай улсын эмийн зах зээлд “Комикс” нэртэй эмээс гадна Декстрометорфан бодис агуулсан худалдаалагдах зөвшөөрөлтэй буюу бүртгэлтэй 41 нэр төрлийн эм байгаа (ЦЕГ, 2019) тухай судалгаа хийсэн байдаг.

Энэ төрлийн эмийг ихэвчлэн ханиалгын шинж тэмдгийг дарах, цэр ховхлох болон гистамины эсрэг ууж хэрэглэдэг байна.

Цаашид DXM бодис болон комикс эмийг хууль бусаар хэрэглэж мансуурдаг, зарж борлуулдаг залуучуудын тоо нэмэгдэж, улмаар хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгч, донтогч болох, гэмт хэрэг үйлдэх, эрүүл мэндээрээ хохирч, амь насаа алдаж болзошгүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь нийгмийн сөрөг үзэгдлүүдийн дунд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдалд жилээс жилд хүндэрч, мансууруулах эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах гэмт хэргүүдийн нилээд хэсэг нь нуугдмал байгаа нь тухайн төрлийн гэмт хэргийн нийгмийн аюул өсөх хандлагатай, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийх, эрчимжүүлэх шаардлага гарч байгааг харуулж байна (Б.Болдбаатар, 2012).

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн эргэлтэд хяналт тавих зорилгоор зохион явуулсан арга хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага, эмийн сангуудын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хадгалах, худалдах, иргэдэд үйлчилж байгаа одоогийн тогтолцоо нь замбараагүй, хууль, журам, стандартыг дагаж мөрддөггүй, эмийн сангийн ажилчид холбогдох хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэлгүй байдал нөлөөлж байна.

Мөн сэтгэцэд нөлөөт эмийн жорын нууцлал хангалтгүй, дуурайлган хийх боломжтой, жор бичилт, зарцуулалтад тавих хяналт сул зэрэг нь сэжигтэй этгээдүүд мансуурах зорилгоор энэ төрлийн эм, тариаг худалдан авах, эмийн сангийн ажилчид албан тушаалаа ашиглан завших гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан болж байна.

Хүүхэд, залуучууд тайвшруулах, өвчин намдаах үйлчилгээтэй эмийг мансуурах зорилгоор хэрэглэдэг талаар бие биеэсээ сонсох, даган дуурайх, цахим сүлжээнд энэ төрлийн мэдээлэл хяналтгүй цацагддаг, телевизийн сувгуудаар хэрэглэж байгаа байдлыг үзүүлж байгаа нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх сэдэл төрүүлдэг.

Гэр бүл салалт, “Ковид 19” цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмийн үеийн хориглолт, хязгаарлалтаас үүдэлтэй иргэдийн дунд бий болсон стресс, улс төрийн эмх замбраагүй байдал, авилгал, хээл хахууль, албан тушаалын байдлаа урвуулан

ашиглахтай холбоотой улс төрчдийн талаарх сөрөг мэдээлэл олон нийтийн сүлжээ, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж байгаа нь өсвөр үе, залуучуудын нийгмийн баримжаа, үнэт зүйлээ алдагдахад хүргэж, тэдний хувьд бусад байдлаар тайвшрах тэмүүллийг бий болгож байна.

Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагааг холбогдох байгууллагаас эрчимжүүлэн таслан зогсоож байгаа нь уг бодисын хамааралтай иргэдийг зах зээлд худалдан борлуулж буй бусад мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэх эрсдлийг бүрдүүлж байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн эргэлтэд тавих хяналтад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бодисыг эргэлтэд оруулж байгаа эрүүл мэнд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад хийх хяналт шалгалтыг сайжруулж, албан тушаалтан нарт холбогдох хууль, журам, стандартын талаар сургалт мэдээлэл өгөх,

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг өндөр өртөгтэй элэгний эм, нийгмийн даатгалын хөнгөлөлттэй эмийн нэгэн адил цахим жорын системд шилжүүлэх ажлыг ЭМЯ, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар зохион байгуулах,

Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан нийгэмд, тэр дундаа хүүхэд, эцэг эхчүүдэд чиглэн энэ төрлийн гэмт хэргийн ойлголт, хор хөнөөлийн талаархи сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх ажлыг тогтмол, зохион байгуулах,

Өсвөр үе, залуучуудын хууль бус хэрэглээ, түүний шалтгаан нөхцөлийг судлах, арилгах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар суурь болон хавсарга судалгааг тогтмол гаргаж хэвших,

Мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг илрүүлэгч тестийг нийтийн эмийн сангаар худалдаалж, эцэг эхчүүд хүүхдүүдээ хянах, далд хэрэглэгч нарыг эрт илрүүлэх боломжоор хангах

Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гаалийн ерөнхий газар, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрууд нь тус бүрдээ бүртгэл судалгаатай, тогтмол мэдээлэл солилцох нэгдсэн цахим сан ашигладаггүй, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд мөн тус тусдаа нягтлан бодох бүртгэлийн программтай байгаа нь улсын хэмжээнд импортлосон, үйлдвэрлэсэн, эргэлтэд орсон, устгасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн нэгдсэн статистик, мэдээ гаргах, хяналт тавих, үнэлгээ, дүгнэлт хийхэд хүндрэлтэй байгааг шийдвэрлэх,

Мансуурах гэмт явдалтай эрүүгийн хуулиар тэмцэхэд олон улсын мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад ороогүй боловч хүүхэд, залуучууд мансуурах зорилгоор хэрэглэх болсон эмийн бүртгэлээс хасагдсан Анданте, хориглосон DXM, дотоодын сэтгэцэд нөлөөт эмийн хяналтад орсон Трамадол, жоргүйгээр нийтийн эмийн сангаар зарагдаж байгаа Комикс зэрэг эм, бодисыг эрүүгийн хуулийн 18.5.3, 20.7-20.10-т заасан зүйлээр шалгах гэмт хэргийн шинжгүй, харин эрүүгийн хуулийн 20.14-д /Зохих зөвшөөрөлгүйгээр эм, эмийн түүхий эд, биобэлдмэл эмнэлгийн хэрэгсэл импортлох, худалдах/ гэмт хэргийн шинжтэйг хууль хэрэгжүүлэгч нар өөрсдийн чиг үүргийг хүрээнд тайлбарладаг, ашигтай байдлаар илтэд гуйвуулан хууль хэрэглэдэг асуудлыг таслан зогсоож, нэг мөр ойлгож ашиглах,

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд Монгол Улсад хориглосон болон шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисын жагсаалттай байхаар зохицуулалт нэмж, НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай”, “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” конвенцийн жагсаалтад орсон эм, бодистой нэгэн адил хяналт тавьж, хууль бус үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг судлах, цаашлаад эрх зүйн орчинг бий болгох,

Манай улсын өсвөр үе, залуучууд мансуурах зорилгоор хэрэглэх болсон Залеплон /Анданте/, Декстрометорфан /DXM/, Трамадол зэрэг бодисын талаар НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба /UNODC/, мансууруулах бодисын хяналтын хороо /INCB/, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /WHO/-д тогтмол мэдээлэх. Өсвөр үе, залуучуудыг энэ төрийн эм, бодист донтох, мансуурах гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдэлд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансуулах болон сэтгэцэд нөлөөт эмийн Б жагсаалтад “Dextromethorphan” бодисыг нэмж оруулан, “Комикс” эмийг Монгол Улсын эмийн бүртгэлээс хасуулах эсвэл сэтгэцэд нөлөөт эмийн тусгай жороор борлуулах зохицуулалт хийх арга замаар шийдвэрлэх боломжтой байна.

Bibliography

Azemi, F. (2019). National Strategy Against Narcotics, Drug Control Policy, and Law Enforcement Experiences in Kosovo. *Dissertations and Doctoral Studies*, 38-42.

Brook, K. K. (2010). Drug Courts and the Treatment of Addiction: Therapeutic Jurisprudence and Neoliberal Governance. *Doctoral dissertation*, 12-18.

Б.Болдбаатар, Ж. (2012). Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг үйл ажиллагаа. *Хар тамхины гэмт явдал ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл*, 14.

Измайлова.В.В. (2019). Взаимодействие субъектами в борьбе с незаконным оборотом наркотических. *Диссертация*, 12-19.

НҮБ. (2005). Мансууруулах эмийн тухай. *НҮБ-ын 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенц.*, 15+-18.

Мэдээлэл. (2019). Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газар. №19/04 Нью-Йорк, 04.

НҮБ. (2019). Танилцуулга мэдээ. *Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газар*, №19/04 Нью-Йорк.

С.Ю., Ведров. (2019). Взаимодействие оперативных подразделений фсин России с иными субъектами орд в борьбе с незаконным оборотом наркотических Федеральная служба по контролю за оборотом наркотиков Российской. *Диссертация*, 31.

Сленг, Х. (2002). Уголовная ответственность за незаконный оборот наркотических средств и психотропных веществ. *Russian Journal of Criminology*, 26-29.

Х.Доржсүрэн. (2018). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл, байдал, цаашдын хандлага. *Хар тамхины гэмт явдал -ын илтгэлийн эмхэтгэл*, 25.

ЦЕГ. (2019). Хар тамхитай тэмцэх газрын тайлан. *Хар тамхитай тэмцэх газрын тайлан, нөхцөл байдлын мэдээ*, 30.

Монгол Улсын Засгийн Газрын Шийдвэр. (2019). Салбарын шийдвэр.